

“ЭБТ-ийн цэцэрлэгт хүрээлэнд мод тарих, тохижуулах” төсөл

Экологийн боловсролын төв Японы ЖИНСИ (GNC Japan) байгууллагатай хамтран “ЭБТ-ийн цэцэрлэгт хүрээлэнд мод тарих, тохижуулах” төсөл хэрэгжүүлж эхлээд өдгөө 10 жил болж байна. Уг төслийн зорилго нь ЭБТ-ийн цэцэрлэгт хүрээлэнд Монгол орны модлог ургамлын сан хөмрөг бий болгох бөгөөд үүний тулд хүрээлэнд жил болгон мод, сөөг шинээр тарьж, модны төрөл зүйлийг олшруулж байгаагаас гадна сүүлийн жилүүдэд, цэцэрлэгт хүрээлэнг хүүхэд, олон нийтэд модны олон янз байдал болон байгалийг танин мэдүүлэх орчин болгохоор зорин ажиллаж байна. Уг төслийн хүрээнд дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:

- Жил бүр шинээр мод, сөөг тарих, арчлан ургуулах: Өдгөө цэцэрлэгт хүрээлэнд голт бор, монос, өрөл, тэхийн шээг, бургас, гацуур, хуш, мөнгөлөг гацуур, нарс, улиас, гүйлс, буйлс, шинэс, тошлой, үхрийн нүд, чацаргана, улаалзгана, бөөрөлзгөнө, агч зэрэг шилмүүст болон навчит мод, гоёл чимэглэл, жимс жимсгэний 32 зүйлийн 3500 орчим мод, сөөг ургаж байна. Мөн шархуайс, хайлаас модоор амьд хашлага хийж, жил бүр өргөжүүлж байна.
- Цэцэрлэгт хүрээлэнд хайрган зам тавих, замын хамгаалалтын шон суулгах, олс татах, сандал, хогийн сав байрлуулах, гүүр, хаалга, сүүдрэвч хийх зэргээр тохижуулах
- Мод, сөөгний хаяг, сурталчилгааны самбар хийх
- Гүний худаг гаргах, усан хоолой байрлуулах, цөөрөм хийх, цэцэрлэгийн багаж хэрэгсэл олгох зэргээр мод, сөөгний арчилгааг сайжруулах
- “Байгалийн массаж”, “Амьтад хэр хол харайдаг вэ” нэртэй танин мэдэхүйн орчин байгуулах
- Цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн цэвэрлэгээ, арчилгааны ажлыг хийх гэрээт ажилчныг жил бүр цалинжуулах



ЭБТ-ийн захирал Д.Базардорж, GNC байгууллагын тэргүүн Мияаки Иппей нар хүрээлэнд анхны улиас мод тарьсан нь

Цэцэрлэгт хүрээлэн



Хаврын дунд үеэс эхлэн усалгаа, модны арчилгааны ажлыг эхлүүлдэг




Явган хүний зам дагуу амьд хашлага байгуулж байна



Цэцэрлэгт хүрээлэнд шинээр жигд, хуш тарьж байгаа нь



Төслийн хүрээнд цэцэрлэгт хүрээлэнд байгуулсан Хөл нүцгэн явах зам буюу "Байгалийн массаж" өртөө



Төслийн хүрээнд байгуулсан “Амьтад хэр харайдаг вэ?” өртөө



Уг хүрээлэн өдгөө ойр хавийн оршин суугчдын ирэх дуртай, хүүхэд багачуудын цэвэр агаарт салхилж, байгалийн сайхныг мэдэрч, танин мэдэж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлдэг, нийслэлийн цөөн хэдэн ногоон байгууламжийн нэг болжээ.

Экологийн боловсролын төв
2014 он